



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын “Татан буулгах комисс байгуулах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 89 дүгээр тушаал, нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрмийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой тус газрын баланст бүртгэлтэй хөрөнгийг хүлээн авах, холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн баланст шилжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Татан буугдсан байгууллагын хөрөнгийг хүлээн авч, холбогдох байгууллагад шилжүүлэхтэй холбогдуулан зардлын тооцоог гаргаж, ажлын тайланг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Хашцэцэг)-д даалгасугай.

3.Нийслэлийн Өмчийн харилцааны Газрын даргын “Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны .03.. дугаар сарын .03.. өдрийн
А./14 дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Хашцэцэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Эрдэнэчимэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч
	Б.Амарзаяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хөрөнгө хариуцсан ахлах зохион байгуулагч
	Д.Батбаяр	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Нярав
	О.Уранчимэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн Өмчийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн
	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн менежментийн хэлтсийн Өмчийн менежмент хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэмөнх	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн Чингэлтэй дүүрэг хариуцсан мэргэжилтэн